

**“БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК**



**Р.НЯМТУУЛ**

**2019.04.26**

**МӨНГӨН ТООЦООНЫ , ДОТООД ХЭРЭГЦЭЭНИЙ  
\100В\ ТООЛУУР ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: **Мөнгөн тооцооны , дотоод хэрэгцээний \100В\  
тоолуур худалдан авах**

Тендерийн дугаар: **ББЭХС\201902010**

Улаангом хот  
2019 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Мөнгөн тооцооны дотоод хэрэгцээний \100В\ тоолуур худалдан авах ББЭХС\201902010** цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендерт \ [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу\ оролцохыг урьж байна. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 \тавин мянган төгрөгийг\ цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 05-р сарын 09-ны өдрийн 11 цагаас** өмнө өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад нэвтэрч цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 11 цаг 30 минутад** ББЭХС ТӨХК-ийн 202 тоот өрөөнд нээнэ.

Дотоодны давуу эрх тооцохгүй .

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Увс аймаг, Улаангом сум, 10-р баг “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн байр, 2 давхар 202 тоот өрөө , диспетчерийн албаны дарга Г.Нямсамбуу, утас: 94119555, утас/факс: 70453385)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |      |  |
|---|------|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.   |
|   | 2.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.  |
|   | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.   |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 7.1. | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.   |
|   | 7.2. | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.  |
|   | 7.3. | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.  |
| <b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>      | 8.1. | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.             |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерийн баримт бичигт заавал ирүүлэх шаардлагатай материалууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээ</li> <li>- Татварын газрын тодорхойлолт</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тодорхойлолт</li> <li>- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитаар баталгаажсан.</li> <li>- Ашигтай ажилласан жилийн тоо: сүүлийн 1 жил</li> <li>- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 40 000 000 –аас багагүй.</li> <li>- Борлуулалтын орлого: 35 000 000 –аас багагүй</li> <li>- Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: сүүлийн 1 жил</li> </ul>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Увс аймаг, Улаангом сум, 10-р баг, ББЭХС ТӨХК-ийн байр.</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>цахимаар хүлээн авна</b></p> <p>Огноо: <b>2019 оны 05 дугаар сарын 09-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Увс аймаг, Улаангом сум, 10-р баг, ББЭХС ТӨХК-ийн байр.</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>2 давхарт 202 тоот өрөө</b></p> <p>Огноо: <b>2019 оны 05 дугаар сарын 09-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>11 цаг 30 минут</b></p>

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Ажлын тоо хэмжээ** : Диспетчерийн Үндэсний Төвийн Тоолуурын нэгдсэн системд холбогдох боломжтой А1805 маркийн тоолуур 2 ш, 3х57/100 В-ийн тоолуур 20 ш, 3х380 В, 100 А тоолуур 2ш, 3х380 В 5А тоолуур 3 ширхэгийг нийлүүлэх.

2. **Тусгай заалт:**

### 2.1.1. Гурван фазын 380 В-ын тоолуурт тавигдах техникийн шаардлагууд

- Монгол Улсын загварын туршилтанд хамрагдсан байх
- Нарийвчлалын ангилал: 0.5
- Мэдрэх гүйдэл: 1-4 мА
- Ажиллах давтамжийн хязгаар: 50Гц±5%
- Актив, реактив энергийг тарифаар тоолдог байх
- Чадлын хамгийн их утгыг бүртгэдэг байх
- Ачааллын график хадгалдаг байх
- Фаз тус бүрийн хүчдэл, гүйдэл, чадлын коэффициент, сүлжээний давтамжийн хэмжээг тооцдог байх
- Гадны төхөөрөмжтэй холбогдох арга: RS-485, IR (Хэт улаан туяа)
- Батарейны ажиллах хугацаа: 10 жилээс багагүй
- Батарейны цэнэгийн хэмжээг тоолуурын дэлгэцнээс харах боломжтой байх
- Үйлдвэрийн баталгаат хугацаа: 36 сараас багагүй
- Тоолуурын цагийг тохируулах боломжтой байх
- Тоолуурын заалтыг тэглэх боломжтой байх
- Тоолуурын програм хангамжид нэвтрэх эрхийг нууц кодоор хамгаалах, уг нууц кодыг өөрчлөх боломжтой байх
- Тоолуурын нүүр дээрээс үйлдвэрлэгчийн нэр, тоолуурын марк, нарийвчлалын ангилал, үйлдвэрлэсэн он, ажиллах хүчдэл, гүйдэл, максимум гүйдэл, тоолуурын тогтмол, хамгаалалтын зэрэг(IP64), Тоолуурын утасны тоо(3 буюу 4) зэргийг харах боломжтой байх
- Тоолуур нийлүүлэгдэхээс өмнө сургалт явагдсан байх

### 2.1.2. 100 В-ын тоолуурт тавигдах техникийн шаардлагууд

- Монгол Улсын загварын туршилтанд хамрагдсан байх
- Нарийвчлалын ангилал: 0.2S, 0.5
- ДҮТ-ийн Тоолуурын Нэгдсэн Системд холбогдох боломжтой тоолуур байх
- Ажиллах хүчдэл: 3х57/100В
- Гүйдэл: 1-5(10) А
- Мэдрэх гүйдэл: 1-4 мА
- Ажиллах давтамжийн хязгаар: 50Гц±5%
- Жин: 2кг-аас ихгүй
- хугацаа: 30 жилээс доошгүй
- Цахилгаан эрчим хүчийг 3 буюу түүнээс дээш тарифаар тооцох боломжтой байх
- Актив, реактив энергийг тоолдог байх

- Чадлын хамгийн их утгыг бүртгэдэг байх
- Ачааллын график хадгалдаг байх
- Фаз тус бүрийн хүчдэл, гүйдэл, чадлын коэффициент, сүлжээний давтамжийн хэмжээг тооцдог байх
- Гадны төхөөрөмжтэй холбогдох арга: RS-485, IR (Хэт улаан туяа)
- Батарейны ажиллах хугацаа: 10 жилээс багагүй
- Үйлдвэрийн баталгаат хугацаа: 36 сараас багагүй
- Батарейны цэнэгийн хэмжээг тоолуурын дэлгэцнээс харах боломжтой байх
- Тоолуурын цагийг тохируулах боломжтой байх
- Тоолуурын заалтыг тэглэх боломжтой байх
- Тоолуурын програм хангамжид нэвтрэх эрхийг нууц кодоор хамгаалах, уг нууц кодыг өөрчлөх боломжтой байх
- Тоолуурын програмын хэл, ашиглалтын заавар монгол, англи хэл дээр байх
- Нийлүүлэгдэх тоолуурын програм хангамж 2 хувь, холболтын протокол, эх код (Source code)-ийг ашиглагч захиалагчид ирүүлсэн байх
- Тоолуурын нүүр дээрээс үйлдвэрлэгчийн нэр, тоолуурын марк, нарийвчлалын ангилал, үйлдвэрлэсэн он, ажиллах хүчдэл, гүйдэл, максимум гүйдэл, тоолуурын тогтмол, хамгаалалтын зэрэг(IP64), Тоолуурын утасны тоо (3 буюу 4) зэргийг харах боломжтой байх
- Тоолуур нийлүүлэгдэхээс өмнө сургалт явагдсан байх

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
  - 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
    - 1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувьЭнд жагсаасан баримт бичгийг бараа ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
4. Төлбөр (ГЕН – 7)

Барааг хүлээн авсаны дараа зарлагын падааныг үндэслэн төлбөрийг 100 % шилжүүлнэ.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup>
  - 7.1. Алданги оногдуулах хувь: 0.3%

Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн 10% хэтрэхгүй.

---

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____ (Тамга, тэмдэг)	_____ (Тамга, тэмдэг)
_____ (Гарын үсэг)	_____ (Гарын үсэг)
_____ (Албан тушаал)	_____ (Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*